



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Цаг агаарын аюулт үзэгдлээс
урьдчилан сэргийлэх тухай

Цаг уур, орчны шинжилгээний газраас энэ сарын сүүлийн 10 хоногт Улаанбаатар хотод хүйтний эрч -40 хэмд хүрч эрс чангарах, ихэнх нутгаар хүчтэй салхилж зарим үед 16-18м/с хүрч цасан шуурга шуурч, зам даваа цас, шуурганд хаагдах, хальтиргаа гулгаа үүсч зам тээврийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах нөхцөл бүрдэх төлөвтэй байгаа тул нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад ДААЛГАХ нь:

1. Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд гарахаас өмнө шалгаж, даалгаварын хуудас олгон үйлчилгээнд гаргах, зуны дугуйтай хөдөлгөөнд оролцохгүй байх

2. Цаг агаар, замын гадаргуу, тээврийн хэрэгслийн онцлогт тааруулан хурдаа тохируулан замын хөдөлгөөнд оролцох

3. Сүүлийн үед зарим шатахуун түгээх станцууд зуны дизель түлш нийлүүлснээс нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх тохиолдол гарсан тул онцгой анхаарч, шатахууныг нөөцлөн тасалдуулахгүй ажиллах

4. Үйлчилгээний цагийн хуваарийг чанд мөрдөж, ялангуяа хот орчмын болон хотын захын алслагдсан хороодод хүрч үйлчилдэг чиглэлүүдийн интервалыг алдуулахгүйгээр нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлэх

5. Техникийн түргэн тусламж, чирэгч автомашиныг шаардагдах шатахуун тосолгооны материал, сэлбэг хэрэгслээр ханган хуваарийн дагуу ажиллуулах

6. Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин, доголдол үүсэж байгаа болон үйлчилгээг цаашид явуулах боломжгүй байдал үүссэн чиглэлүүдийн талаар тус газрын тээвэр зохицуулагчид шуурхай мэдээлж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллах

7. Аж ахуйн нэгжүүд нөөц тээврийн хэрэгсэл болон жолоочийг өдөр бүр тогтмол тоогоор бэлэн байлгах

8. Автобусны дулаалга, халаалтыг сайжруулах, түүнд тавих хяналтын сайжруулах

9. Жолоочийг үйлчилгээнд гарахаас өмнө замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 36 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлгөөнт утас хэрэглэх журам зөрчихгүй байх талаар зааварчилгаа өгөх

10. 2018 оны 01 дүгээр сарын 20-ноос 01 дүгээр сарын 30-ны өдрүүдэд үйлчилгээний талаарх мэдээллийг өдөр бүр 22:00 цагт тус газрын тээвэр зохицуулагчид мэдээлэл өгөх

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийн явцад хяналт тавьж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж, ажлын явц, биелэлтийг танилцуулж байхыг тус газрын Захиргаа удирдлагын санхүүгийн хэлтэс, Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс, Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс, Тээврийн хяналтын хэлтсийн дарга нарт даалгаж байна.

ДАРГА  Д.ОТГОНБААТАР

